



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.15 № 3/474
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



“ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР” ТӨҮГ- ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

САГ-ын дарга,
Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг:

Аудитын менежер

Я.Самбууням

Утас: 261883

Цахим хаяг:

Аудитор: Б.Баярмаа

Утас: 260512

Цахим хаяг:

Бодит бүртгэл Аудит ХХК

Захирал Б.Бямбасүрэн

Утас: 88118264

Чанарын хяналтын менежер

Б.Бурмаа

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээ

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8.9.8 –д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны 9 дүгээр сарын 19-ны өдрийн А/93 тушаалаар батлагдсан журмын 2,7 дугаар заалтыг үндэслэн улсын төсвөөс санхүүждэг, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага ахуй нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/8/CAT-УТҮГ/ аудит хийх ажлыг Бодит бүртгэл аудит ХХК санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар”ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлангийн программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 20-ноос 2017 оны 3 дугаар сарын 10–ны хооронд хийхээр төлөвлөн Бодит бүртгэл аудит ХХК-ийн аудитор хэрэгжүүлэв.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2017 оны 2 дугаар сарын 20-нд цахимаар болон хэвлэсэн байдлаар Бодит бүртгэл аудит ХХК-нд ирүүлсэн байна.

Бодит бүртгэл аудит ХХК аудитыг 2017 оны 2 дугаар сарын 20-наас 2017 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, 2017 оны 3 дугаар сарын 15-нд “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ –ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, компанийн тухай, Венийн конвенц зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль нь 2016 оны 01-р сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ нь 1951 онд “Элчингүүдэд үйлчлэх тасаг” нэртэйгээр анх нэг орон тоотой байгуулагджээ. 1958 онд “Дипломат корпуст үйлчлэх товчоо”, 1977 оноос ГХЯ-ны дэргэдэх, Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйн газар болон өргөжин өнөөг хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагаа: Монгол Улсын Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаад орон, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээрийн асуудал, байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад хяналт тавих бүрэн эрх байдаг. Монгол Улс Венийн конвенцод нэгдэн орсноор уг гэрээнд заасны дагуу хүлээн авагч улс Дипломат төлөөлөгчийн газрыг байр орон сууцаар хангах, тэдгээрийн ая тухтай оршин суух бүх нөхцөлийг хангах үүрэг хүлээсний дагуу уг чиг үүргийг гүйцэтгэж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансны уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг

тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансанд түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 7 горим, сорил 38-ыг гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна. Мөн нягтлан бодох бүртгэлийн бодлого нь санхүүгийн программ хангамжтай нийцсэн байна.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программ боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын түвшин:

"Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ-ийн системийн хэмжээнд төлөвлөлтийн үе шатанд материаллаг төвшний хэмжээ буюу алдааг хүлээн зөвшөөрөх нийт хэмжээг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувь буюу 22.4 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд, гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн баримжаанаас зөрүүтэй зүйл гараагүй болно.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн ажиллаж байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ нь 2016 оны батлагдсан төлөвлөгөөг сар, улирлын хуваарийн дагуу гүйцэтгэлийг хангах, зорилтот түвшингийн зардлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

2016 онд үйл ажиллагааны орлогоор 5,344.5 сая.төгрөг, үйл ажиллагааны бус орлогоор 192.0 сая.төгрөг нийтдээ 5,536.5 сая.төгрөг орлого олж, 5,504.8 сая.төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс үйл ажиллагааны урсгал зардалд 5,496.1 сая.төгрөгийг зарцуулж, 30.9 сая.төгрөгийн ашигтай ажилласан үзүүлэлттэй байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны цахим хуудсанд тавигдсан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 6,873.3 сая төгрөгийн орлого, 2,904.3 сая төгрөгийн зардал нийт 258 ажил гүйлгээ мөн хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт зэрэг 45 ажил үйлчилгээг нийт 881.5 сая төгрөгийг ил тод, нээлттэй мэдээлсэн байна. .

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 38 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлбол: Тайлант онд дансны өр, авлага өсгөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, орлого, цалин, шатахуун, бараа материал, гадаад албан томилолтын зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 75 хувь, мөнгөн хөрөнгийн 83,2 хувь, нийт зардлын 84,5 хувь, нийт хөрөнгийн 89 хувийг тус тус эзэлж байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах зөрчил илэрсэн байна. Үүнд

Тайлант онд дансны авлага 195.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
Шийдвэрлэсэн : Зөвлөмж өгөх

Материаллаг бус хэмжээний дараах зөрчил илэрсэн байна. Үүнд

2016 оны 11,12-р саруудын хөтлөгдвөл зохих хүнсний нэр төрлийн тайлан гаргаагүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй зэрэг зөрчил нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Эдгээр зөрчлүүд нь НББ-ийн тухай хуулийн 7.4-д “Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.
Шийдвэрлэсэн : Зөвлөмж өгөх

Тайлант оны 10,11,12-р сард жолооч нарын шатахууны тооцоог эд хариуцагч нярваар тооцоог бодуулсан, мөн механикч оношилгоо хийж авто машины сэлбэгийг өөрөө бэлтгэн нийлүүлж байгаа зэрэг зөрчил илэрлээ. Энэ нь байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтыг зөрчиж хяналтыг сулруулж, хөрөнгө эзгүйдэх эрсдэлийг бий болгож байна.
Шийдвэрлэсэн : Зөвлөмж өгөх

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

2016 оны 04-р сарын 18-ны өдрийн засгийн газрын 223 тогтоолоор “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 5.336.9 сая төгрөгийн үнэ бүхий “Дипломат-95 цогцолборын 80 айлын орон сууцны барилга мөн 36.9 сая төгрөгийн 30 авто машины гараашийн хамт гадаад хэргийн яаманд шилжүүлэх тогтоол гарсан, мөн оны 06-р сарын 09-ны өдрийн 315 дугаар тогтоолоор тус барилгыг Гадаад хэргийн яамны албан хаагчдад үнэ төлбөргүй хувьчлах тогтоол гарсан боловч 2016 оны 12-р сарын 31-ны байдлаар хөрөнгө нь ДБҮЭГ үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хэвээр байна.

Ази, Европын дээд түвшний 11-р уулзалтанд зориулж БНХАУ-аас буцалтгүй тусламжаар ирсэн зочид буудлын тавилгыг 2016 оны 08-р сарын 15-нд АСЕМ үндэсний зөвлөлийн зохион байгуулах хорооноос ДБҮЭГ-т хүлээлгэн өгсөн байна. Үүнээс Стандарт өрөөний 316 ком, Люкс өрөөний 232 ком, Ерөнхийлөгчийн өрөөний 30 ком нийт 578 ком тавилгын 1.273.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 2016 оны 12-р сарын 31-ны байдлаар 368.7 сая төгрөг төвлөрүүлж 905.0 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 195,8 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба уг зөрчилд зөвлөмж өглөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд . “Бодит Бүртгэл Аудит” ХХК-ний хийсэн аудитаар 100.8 сая төгрөгийн албан шаардлага, зөвлөмж өгсөн бөгөөд эдгээрийн зөвлөмжийн 50.4 хувийг хэрэгжүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, хавсралтууд 5 хуудсыг тус тус хавсаргав.



“ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР” ТӨҮГ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 3 зүйлс:

Асуудал 3	
Авлага	1
Анхан шатны баримтын хөтлөлт	2
Мөнгөн хөрөнгө.....	3

2017 оны 3 дугаар сар 10

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг : “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан : “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын удирдлага болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Авлага	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд дансны авлага 195.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийг мөрдөж, авлага барагдуулах арга хэмжээг авч ажиллах

Эрсдэлүүд

Авлага их хэмжээгээр найдваргүй болох, батлагдсан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Анхан шатны баримтын хөтлөлт	Тэргүүлэх ач холбогдол №2
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2016 оны 11,12-р саруудын хөтлөгдвөл зохих хүнсний нэр төрлийн тайлан гаргаагүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй зэрэг зөрчил нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Эдгээр зөрчлүүд нь НББ-ийн тухай хуулийн 7.4-д “Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн тухай хууль, СТОУС-ыг мөрдөж цаашид зөрчлийг давтахгүй байх арга хэмжээг авч ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, орлого зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх, төсвийг зориулалт бусаар зарцуулах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 3: Зардал	Тэргүүлэх ач холбогдол №3
--------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант оны 10,11,12-р сард жолооч нарын шатахууны тооцоог эд хариуцагч нярваар тооцоог бодуулсан, мөн механикч оношилгоо хийж авто машины сэлбэгийг өөрөө бэлтгэн нийлүүлж байгаа зэрэг зөрчил илэрлээ. Энэ нь байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтыг зөрчиж хяналтыг сулруулж, хөрөнгө эзгүйдэх эрсдэлийг бий болгож байна

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн тухай хуулийг мөрдөж, цаашид зөрчлийг давтахгүй байх арга хэмжээг авч ажиллах

Эрсдэлүүд

Байгууллагын дотоод хяналт ажиллахгүй байх, батлагдсан төсвөөс гадуур зардал гаргах, зориулалт бусаар зарцуулах, холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

**“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,255,400,455.44	2,748,796,014.03
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	54,518,153.44	1,316,322,870.20
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	2,914,900.26	1,536,031.65
31110	Төгрөг	2,906,657.80	1,488,182.88
31120	Гадаад валют	8,242.46	47,848.77
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	51,603,253.18	1,314,786,838.55
3121	Төгрөг	51,550,020.24	77,707,590.25
31213	Арилжааны банк дахь харилцах	51,550,020.24	77,707,590.25
3122	Гадаад валют	53,232.94	1,237,079,248.30
31223	Арилжааны банк дахь харилцах	53,232.94	1,237,079,248.30
33	АВЛАГА	720,171,650.92	916,017,090.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	16,981,928.06	224,212,583.03
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	1,374,463.44	42,926,890.56
335	Бусад авлага	701,815,259.42	648,877,616.41
3351	Байгууллагаас авах авлага	701,690,059.42	648,877,616.41
3352	Хувь хүмүүсээс авах авлага	125,200.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	480,710,651.08	516,456,053.83
351	Түүхий эд материал	8,113,795.65	9,109,962.65
35110	Тусгай зориулалттай материал	8,113,795.65	9,109,962.65
354	Хангамжийн материал	472,596,855.43	507,346,091.18
35410	Бичиг хэргийн материал	2,757,518.71	1,403,362.00
35420	Аж ахуйн материал	66,531,306.65	38,116,936.04
35430	Сэлбэг хэрэгсэл	480,000.00	-
35450	Барилгын засварын материал	21,676,552.58	19,806,046.08
35460	Хүнсний материал	1,478,861.49	1,120,615.86
35470	Бусад хангамжийн материал	379,672,616.00	446,899,131.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,090,849,426.05	16,993,559,968.04
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,090,849,426.05	16,993,559,968.04
391	Газар		
392	Биет хөрөнгө	18,040,849,426.05	16,941,701,420.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	23,518,167,874.02	23,518,167,874.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,149,093,901.88)	(7,705,206,397.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,062,608,246.19	3,037,748,726.19
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,832,933,551.06)	(2,229,238,662.13)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	546,986,783.52	454,294,412.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	(365,233,233.31)	(346,463,819.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	509,475,756.82	488,843,710.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(249,128,548.25)	(276,444,424.10)
393	Биет бус хөрөнгө	50,000,000.00	51,858,547.95
39301	Програм хангамж	892,300.00	3,202,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(892,300.00)	(1,343,752.05)
39303	Бусад биет бус хөрөнгө	51,595,000.00	51,595,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,595,000.00)	(1,595,000.00)
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	19,346,249,881.49	19,742,355,982.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	33,954,916.00	399,187,681.47
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	33,954,916.00	399,187,681.47
413	Өглөг	33,954,916.00	399,187,681.47
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,062,524.15	535,061.78
4136	Бусад өглөг	29,892,391.85	398,652,619.69

41361	Байгууллагад төлөх өглөг	28,067,791.85	398,135,413.69
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,824,600.00	517,206.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>19,312,294,965.49</u>	<u>19,343,168,300.60</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	19,312,294,965.49	19,343,168,300.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,843,643,916.35	5,843,643,916.35
51101	Өмч: - төрийн	5,843,643,916.35	5,843,643,916.35
512	Хуримтлагдсан үр дүн	8,496,315,363.13	8,527,597,202.44
51210	Өмнөх үеийн үр дүн	9,432,862,570.87	8,496,723,867.33
51220	Тайлант үеийн үр дүн	(936,547,207.74)	30,873,335.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,972,335,686.01	4,971,927,181.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>19,346,249,881.49</u>	<u>19,742,355,982.07</u>

**“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,145,774,743.20	5,344,458,103.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,372,837,413.20	5,344,452,678.32
120	Нийтлэг татварын бус орлого	4,372,837,413.20	5,344,452,678.32
120002	Хүүгийн орлого	390,252.50	5,861,951.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,362,439,925.23	5,338,590,726.91
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,179,277,169.62	4,957,314,633.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	183,162,755.61	381,276,093.56
120009	Бусад орлого	10,007,235.47	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,772,937,330.00	5,425.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,731,294,330.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,643,000.00	5,425.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,600,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааныг хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,000.00	5,425.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,989,351,938.43	5,496,926,138.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,989,351,938.43	5,496,926,138.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,752,812,010.65	5,496,920,713.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,367,946,205.47	-
210101	Үндсэн цалин	1,300,525,005.47	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	67,421,200.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,675,401.07	-
210201	Тэтгэврийн даатгал	158,675,401.07	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,478,948,708.17	-
210301	Гэрэл, цахилгаан	537,093,662.00	
210302	Түлш, халаалт	853,529,828.02	
210303	Цэвэр, бохир ус	88,325,218.15	
2104	Хангамж, бараа материалын зардал	129,600,160.94	-
210401	Бичиг хэрэг	11,124,457.05	
210402	Тээвэр, шатахуун	70,869,525.20	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,890,550.15	
210404	Ном, хэвлэл	739,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,776,421.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,200,207.54	
2105	Нормативт зардал	140,530,957.40	-
210502	Хоол, хүнс	140,530,957.40	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	211,842,866.41	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,849,970.00	
210604	Урсгал засвар	208,992,896.41	
2107	Томилолт, зочны зардал	57,137,707.55	-
210701	Гадаад албан томилолт	25,072,531.20	
210702	Дотоод албан томилолт	1,618,380.00	
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	30,446,796.35	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,394,191.72	4,406,024,275.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,692,847.80	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,100,700.00	
210803	Даатгалын үйлчилгээ	50,000,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,878,900.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,723,300.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,814,572.29	
210807	Газрын төлбөр	2,000,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	183,871.63	
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/		3,532,184,947.56
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/		803,009,012.37
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/		
210813	Бусад зардал /ТӨҮГ/		70,040,891.50
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/		789,423.84

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,118,735,811.92	1,090,896,438.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,116,235,811.92	1,090,896,438.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,236,539,927.78	5,425.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,356,656.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	38,492,926.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,863,730.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,178,183,271.78	5,425.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,178,183,271.78	5,425.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(843,577,195.23)	(152,468,035.04)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	7,740,600.76	192,044,390.07
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	7,740,600.76	192,044,390.07
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	100,710,613.27	8,703,019.92
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	97,463,455.52	8,703,019.92
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	3,247,157.75	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(92,970,012.51)	183,341,370.15
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(936,547,207.74)	30,873,335.11

**“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газры хувь оролцоон нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,843,643,916.35	4,985,419,430.01	9,419,778,826.87		20,248,842,17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,843,643,916.35	4,985,419,430.01	9,432,862,570.87	0.00	20,261,925,91
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-13,083,744.00			-13,083,74
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн			-936,547,207.74		-936,547,20
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,843,643,916.35	4,972,335,686.01	8,496,315,363.13	0.00	19,312,294,96
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,843,643,916.35	4,959,251,942.01	7,559,768,155.39	0.00	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			408,504.20		408,50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,843,643,916.35	4,972,335,686.01	8,496,723,867.33	0.00	19,312,703,46
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-408,504.20			-408,50
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
D08	Тайлант үеийн үр дүн			30,873,335.11		30,873,33
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,843,643,916.35	4,971,927,181.81	8,527,597,202.44	0.00	19,343,168,30

**“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,934,455,762.22	5,620,207,674.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,161,518,432.22	5,620,202,249.80
120	Нийтлэг татварын бус орлого	4,161,518,432.22	5,620,202,249.80
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого	390,252.50	5,861,951.41
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,161,128,179.72	5,614,340,298.39
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,001,330,835.25	4,972,314,649.15
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	159,797,344.47	642,025,649.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,772,937,330.00	5,425.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,731,294,330.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,731,294,330.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,643,000.00	5,425.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,600,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,000.00	5,425.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	7,887,214,897.78	4,356,092,958.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,887,214,897.78	4,356,092,958.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,641,269,743.00	4,356,087,533.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,371,197,542.87	1,064,310,456.38
210101	Үндсэн цалин	1,303,776,342.87	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	67,421,200.00	
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		1,064,310,456.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,313,960.13	246,100,000.00
210201	Тэтгэврийн даатгал	151,313,960.13	
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		246,100,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,480,040,448.17	1,778,251,577.09
210301	Гэрэл, цахилгаан	538,185,402.00	
210302	Түлш, халаалт	853,529,828.02	
210303	Цэвэр, бохир ус	88,325,218.15	
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		1,778,251,577.09
2104	Хангамж, бараа материалын зардал	108,520,422.15	741,676,108.20
210401	Бичиг хэрэг	6,928,406.00	
210402	Тээвэр, шатахуун	64,173,380.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,394,250.15	
210404	Ном, хэвлэл	739,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,978,921.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,306,465.00	
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/		158,064,093.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		583,612,015.20
2105	Нормативт зардал	165,393,264.90	-
210502	Хоол, хүнс	163,481,812.90	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,911,452.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	214,736,534.39	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,971,770.00	
210604	Урсгал засвар	187,764,764.39	
2107	Томилолт, зочны зардал	56,528,956.67	-
210701	Гадаад албан томилолт	23,168,704.20	
210702	Дотоод албан томилолт	783,000.00	
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	32,577,252.47	

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,038,613.72	525,749,391.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,242,597.80	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,100,700.00	
210803	Даатгалын үйлчилгээ	50,000,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,870,140.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,453,612.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,187,692.29	
210807	Газрын төлбөр	2,000,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	183,871.63	
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		124,497,619.28
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/		47,799,440.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/		353,452,332.09
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,245,945,154.78	5,425.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,593,083.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,774,280.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,818,803.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,189,352,071.78	5,425.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,189,352,071.78	5,425.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	47,240,864.44	1,264,114,716.76
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	(2,310,000.00)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	(2,310,000.00)
2200	Дотоод эх үүсвэрээр	-	(2,310,000.00)
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		(2,310,000.00)
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	2,310,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	47,240,864.44	1,266,424,716.76
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,964,716.77	54,518,153.44
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	54,518,153.44	1,316,322,870.20